# БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨТҮГ
# "АМНЫ ХААЛТАА ЗҮҮЦГЭЭЕ" АЯНЫ ТАЙЛАН

2020 оны 06 дугаар сарын 02-ны өдөр — Багануур дүүрэг

| № | Үзүүлэлт | Хэрэгжүүлсэн ажлууд |
|---|---|---|
| 1. | Иргэд хоорондоо зөвхөн 1-4м зайнаас харьцах, бие биедээ шаардлага тавих, хувь хүний ухамсар, соёлыг дэлгэрүүлэх, амны хаалтыг зүүж хэвших, гэртээ байх дэглэмийг бүх түвшинд чандлан сахих хяналтыг чангатгах | 2020 оны 02 дугаар сараас эхлэн Албан хаагчдын амны хаалтын хэрэглээг хэвшүүлэн, ажилчдыг Паркийн нэгж болох Монхимо ХХК-ийн бүтээгдэхүүн /санитол/ гар халдваргүйжүүлэх нөхцөлөөр хангаж, өглөө бүр ажлын байранд чийгтэй цэвэрлэгээ хийж, хаалганы бариулыг 2 цаг тутамд спиртээр тогтмол ариутгаж, 7 хоног бүрийн Баасан гарагт их цэвэрлэгээ хийж байна.<br>Нийслэлийн Засаг даргын 02 дугаар сарын 28-ны өдрийн А/268 дугаар захирамж, Нийслэлийн онцгой комиссын 03 дугаар сарын 02-ны өдрийн өргөтгөсөн хуралдааны 07 дугаар тэмдэглэл, Багануур дүүргийн Засаг даргын 03 дугаар сарын 03-ны өдрийн А/76 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангаж Газрын даргын 03 дугаар сарын 05-ны өдрийн А/16 дугаар тушаалаар холбогдох албан хаагчдын ажлын цагийг 1 цагаар хорогдуулан ажиллуулж байна. |
| 2. | Төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгжүүд зөвхөн амны хаалт хэрэглэсэн хүнд үйлчилдэг хатуу дэглэм тогтоох | Шинэ төрлийн корона вирус бүртгэгдсэнтэй холбогдуулан Амны хаалтгүй иргэдэд үйлчлэхгүй хатуу дэглэм тогтоож уриалгыг хаалганы гадна байршуулсан.<br><br> |
| 3. | Халдварын эрсдлийг бууруулах зорилгоор хэвлэл мэдээллийн бүх байгууллага (телевиз, радио, сонин, бүх төрлийн цахим, багц мессеж)-ээр заавар зөвлөмжийг хүртээмжтэй, давталттай, тасралтгүй хүргэх | Корона вирусын халдвараас урьдчилан сэргийлэх, халдварын эрсдлийг бууруулах зорилгоор ЭМЯ-наас өгч байгаа зөвлөмж, цаг үеийн мэдээг өглөө бүр албан хаагчдад танилцуулан, байгууллагын цахим хуудсанд байршуулж, мэдээллийг тасралтгүй хүргэж байна.<br>Албан хаагчдын ширээ бүрт наасан зөвлөмж<br> |

**Байгууллагын цахим хуудсаар тасралтгүй хүргэж буй мэдээллүүдээс:**



| | | |
|---|---|---|
| 4. | Мэдээлэл, зөвлөгөө, сэрэмжлүүлгийг тусгай тоноглогдсон автомашин болон зарлан мэдээллийн дуут дохиоллын цамхагаар дамжуулж хорооллын дундах зам, нийтийн эзэмшлийн талбайд давтамжтай түгээх, нийгмийн сүлжээгээр “би амны хаалтаа тогтмол зүүдэг” мессеж бүхий амны хаалттай профайл зураг тавих, 10-аас доошгүй найзаа челленжид дуудах аян өрнүүлэх | “Би амны хаалтаа тогтмол зүүдэг” мессеж бүхий амны хаалттай профайл зургийг байгууллагын бүх албан хаагчид нүүр номын хуудсандаа тавьж, 10 найзаа челленжид дуудах 14 хоногийн аянг 2020 оны 05 дугаар сарын 14-ны өдрөөс 2020 оны 05 дугаар сарын 28-ний өдрийн хооронд өрнүүлсэн.<br>Нийт 13 албан хаагчийн 130 найз челленжид дуудагдаж, 125 хүн үргэлжлүүлэн давалгаалж нийт 315 хүн хамрагдсан үр дүнтэй аян боллоо.<br>Амны хаалттай профайл зургаас:<br> |
| 5. | Нийтийн эзэмшлийн гудамж, талбайд ажиллах байнгын эргүүл, байцаагчдын тоог нэмэгдүүлэх, хяналт, шалгалтыг эрчимжүүлэх | НЗД-ын А/191 дүгээр захирамжийн хэрэгжилтийг хангах үүднээс 2020 оны 02 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн Багануур үйлдвэрлэл, технологийн парк нь хуваарийн дагуу явган эргүүлээр ажиллагсдад хяналт тавьж, дүн мэдээг нийслэл, дүүргийн Шуурхай штаб, дүүргийн Онцгой комисст утсаар, Нийслэлийн Эрүүл мэндийн газарт цахим хаягаар өдөр бүр тайлагнаж байна. Мөн эргүүлийн дүн мэдээний 7 хоногийн нэгтгэлийг Нийслэлийн ЗДТГ-ын холбогдох ажилтанд цахимаар тайлагнан ажиллаж байна. |

ХЯНАСАН:
БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК
ОНӨТҮГ-ЫН ДАРГА Ч. ЭЛБЭГСАЙХАН

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:
ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН
КЛАСТЕР ИНЖЕНЕР Э. ЭНХЗАЯА